



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга,
хариуцлагыг дээшлүүлэх тухай

Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй, ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлэх, байгууллагын болон албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх, албан хаагчийг ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг чанд мөрдөн, ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагуудыг ёсчлон биелүүлж, ёс зүйн аливаа зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлэх зорилгоор Гадаадын иргэн, харьяатын газрын төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн удирдлага, албан хаагчдад ДААЛГАХ нь:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх хүрээнд:

1.1.Төрийн албан хаагч бүр хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны нэр хүндийг эрхэмлэн, ёс зүйг сахих;

1.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар хүлээсэн нийтлэг үүрэг, ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын дотоод дэг журмыг сахих, албаны чиг үүргээ шударгаар биелүүлж, хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх соёлыг хэвшүүлэх;

1.3.Хүний эмзэг болон хувийн мэдээллээр бусдыг гутаах, тараахгүй байх, албаны чиг үүрэгт хамаарах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

1.4.Албан хаагчид харилцан бие биедээ хүндэтгэлтэй харьцах, нэгж, хамт олны дотор эерэг уур амьсгал бүрдүүлж, багаар ажиллах.

2.Ажлын хариуцлага, сахилгыг дээшлүүлэх хүрээнд:

2.1."Төрийн албаны үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага MNS7068:2025" стандартыг судалж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2.Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу чөлөө, зөвшөөрөл авах, холбогдох журмын хүрээнд зайнаас ажиллах, удирдлагаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хариуцлагатай биелүүлж, хэрэгжилтийг тайлагнах;

2.3.Албаны дүрэмт хувцсыг журмын дагуу өмсөж, хэрэглэх, албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

2.4.Иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хууль зүйн үндэслэлтэй, бодитой, тодорхой хариу өгдөг байх;

2.5.Албаны чиг үүрэгт холбоогүй, хууль зөрчсөн амлалт өгөхгүй, албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй, үйлчлүүлэгчдэд албаны чиг үүрэг, дотоод үйл ажиллагааны мэдээллийг тараахгүй байх.

3.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1, 8.2 дахь хэсэг, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх чиглэлээр албан даалгаварт заасан үүргийг тус тус зөрчсөн удирдах, гүйцэтгэх албан тушаалтанд ёс зүйн шийтгэл ногдуулах саналыг тухай бүр ирүүлэхийг Ёс зүйн дэд хороо (Н.Дуламсүрэн)-д үүрэг болгосугай.

4.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.1, Төрийн албаны тухай хуулийн 37.1.3, 37.1.7 дахь заалт, ажлын хариуцлага, сахилгыг дээшлүүлэх чиглэлээр албан даалгаварт заасан үүргийг тус тус зөрчсөн удирдах, гүйцэтгэх албан тушаалтанд тухай бүр сахилгын шийтгэл ногдуулахыг анхааруулсугай.

5.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (И.Баатархүү), Ёс зүйн дэд хороо (Н.Дуламсүрэн) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР